

**НЭМЭЛТ АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГЭРЭЭ  
№ НАУ-ГТТА 2022-27**

2022-09-06

Улаанбаатар хот

Энэ гэрээг нэг талаас **2699877** регистрийн дугаартай “Диспетчериин үндэсний төв” ТӨХХК, /цаашид “Гүйцэтгэгч” гэх/ түүнийг төлөөлж, Гүйцэтгэх захирал Г.Балжинням, нөгөө талаас **2680742** регистрийн дугаартай “Батхэрэйд” ХХК /цаашид “Захиалагч” гэх/, түүнийг төлөөлж, Цахилгааны инженер Б.Батсайхан /хамтад нь “Талууд” гэх/ нар Монгол Улсын Иргэний хуулийг удирдлага болгон “Диспетчериин үндэсний төв” ТӨХХК-ийн 2017 оны “Нэмэлт ажил үйлчилгээ явуулах журам”-ыг үндэслэн Талууд дараах нөхцлөөр харилцан тохиролцож байгуулав.

**НЭГ. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ**

- 1.1. Гүйцэтгэгч нь Баянзүрх дүүргийн 12-р хорооны нутаг дэвсгэрт гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн хүрээнд баригдаж байгаа “Serene town” хотхоны цахилгаан хангамжийн горимын тооцоог хийж гүйцэтгэх /цаашид “Гэрээт ажил” гэх/, Захиалагч нь гэрээгээр тохиролцсон төлбөрийг төлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахад энэ гэрээний зорилго оршино.
- 1.2. Энэ гэрээнд тусгагдаагүй бусад харилцааг Монгол улсын Иргэний хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна.
- 1.3. Энэ гэрээний **Хавсралт-1-д “Батхэрэйд” ХХК-иас** Баянзүрх дүүргийн 12-р хорооны нутаг дэвсгэрт гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн хүрээнд баригдаж байгаа “Serene town” хотхоны цахилгаан хангамжийн горимын тооцооны гүйцэтгэх ажлын төлөвлөгөө, үнэ тариф”-ыг хавсаргав. **Хавсралт-1 нь гэрээний салшгүй хэсэг байна.**
- 1.4. Энэ гэрээгээр гүйцэтгэсэн гэрээт ажил нь Талуудын оюуны өмч болох тул гуравдагч этгээдэд дамжуулах болон ашиглуулах тохиолдолд нөгөө Талын зөвшөөрлийг заавал авна.

**ХОЁР. ГЭРЭЭТ АЖЛЫГ ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦАА**

- 2.1 Гүйцэтгэгч нь гэрээт ажлын төлбөрийг төлсөн өдрөөс эхлэн ажлын 45 /дөчин тав/ хоногийн хугацаанд хийж гүйцэтгэнэ.
- 2.2 Захиалагчаас хамаарсан болон Давагдашгүй хүчин зүйлийн нөлөөллөөс бусад тохиолдолд гэрээт ажлыг хугацаанд нь гүйцэтгэнэ.

**ГУРАВ. ГЭРЭЭНИЙ ҮНЭ, ТӨЛБӨР ТООЦОО**

- 3.1 Гэрээт ажлын нийт төлбөр нь татвар хураамж /НӨАТ/ багтсан дунгзэр **13,612,500.00** (арван гурван сая зургаан зуун арван хоёр мянга таван зуу) төгрөг байна.
- 3.2 Энэ гэрээний нийт төлбөрт Гүйцэтгэгчээс гэрээт ажлыг хийж гүйцэтгэх ажлын хөлс, шаардлагатай материал, ажилтны хөлс, бүх татвар, хураамж болон зардал багтсан болно.
- 3.3 Гэрээний төлбөрийг Захиалагч нь Гүйцэтгэгчид **13,612,500.00** (арван гурван сая зургаан зуун арван хоёр мянга таван зуу) төгрөгийг төгрөгийг нэхэмжлэхийг үндэслэн, Худалдаа хөгжлийн банкны 406002860 тоот дансанд шилжүүлнэ.
- 3.4 Гүйцэтгэгч нь Захиалагч гэрээт ажлын төлбөрийг бүрэн төлсөний дараа НӨАТ-ын баримтын бичилт хийнэ.

**ДӨРӨВ. ЗАХИАЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ**

- 4.1 Захиалагч нь Гүйцэтгэгчийг гэрээт ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай ТЭЗҮ, Нэгдсэн сүлжээтэй холбогдох схем, цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын үндсэн тоноглолын өгөгдөл зэрэг бусад шаардлагатай мэдээллээр бүрэн хангана.
- 4.2 Хийгдэх ажлын хэмжээ өөрчлөгдөх, зогсоо шаардлага гарвал Гүйцэтгэгчид урьдчилан мэдэгдэх, гэрээнд заагдаагүй нэмэлт ажил гарвал Гүйцэтгэгчийн шаардлагыг хүлээн авч шийдвэрлэнэ.

- 8.3 Энэ гэрээний нөхцлүүдийг зөрчсөн буюу гэрээт ажлын гүйцэтгэлтэй холбоотой аливаа зөрчил, маргаантай асуудлыг Талууд харилцан зөвшилцэж шийдвэрлэнэ.
- 8.4 Гэрээнээс үүссэн маргааны зөвшилцэлийг эс зөвшөөрсөн Тал нь Монгол Улсын Шүүхээр шийдвэрлүүлнэ.
- 8.5 Энэ гэрээг 2 /хоёр/ эх хувь үйлдэж, баталгаажуулах ба Талууд тус бүр нэг эх хувийг хадгална. Гэрээний эх хувь тус бүр хууль зүйн хувьд адил хүчинтэй байна.
- 8.6 Гэрээт ажлыг Талууд бүрэн хүлээлцэж, төлбөр тооцоог 100 хувь барагдуулсандаар гэрээ дуусгавар болно.

### ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

#### Гүйцэтгэгчийг төлөөлж:

"Диспетчерийн үндэсний төв" ТӨХХК:

Гүйцэтгэх захирал

..... Г.Балжинням

Ерөнхий диспетчерийн албан үүргийг  
тур орлон гүйцэтгэгч

..... Б. Баатар

СЭЗА-ны дарга

..... Т.Бямбажав

333A-ны дарга

..... Ц.Өнөрмаа

ГТА-ны дарга

..... Х.Болд-Эрдэнэ

333A-ны ахлах мэргэжилтэн

..... Ч.Энхжаргал

Гэрээ, эрх зүйн мэргэжилтэн

..... Ч. Отгонбаатар

Гэрээний мэргэжилтэн

..... Д.Алимаа

#### Захиалагчийг төлөөлж:

"Батхэрэйд" ХХК-ийн

Захирал

..... Д.Байгалмаа

Цахилгааны инженер

..... Б.Батсайхан